



ГОЛОМТ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар ...00/02

Улаанбаатар хот

Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.3 дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.9 дэх заалт, Голомт банкны 2026 оны 02 дүгээр сарын 24-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дугаар сарын 06-ны өдөр зарлаж, өглөөний 09:00 цагт, Шангри-Ла зочид буудлын хурлын их танхимд зохион байгуулсугай.
2. Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Голомт Банк ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулга.
 - 2.2 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт.
 - 2.3 2025 оны санхүүгийн аудитлагдсан үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт.
 - 2.4 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоолыг танилцуулах.
 - 2.5 2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2026 оны цалингийн төсөв.
 - 2.6 Голомт Банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4-т заасан шаардлагыг ханган хурал зарласан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:
 - 5.1 Голомт банкны 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
 - 5.2 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
 - 5.3 2025 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт;
 - 5.4 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоол;
 - 5.5 2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2026 оны цалингийн төсөв;
 - 5.6 Голомт Банкны дүрмийн шинэчилсэн найруулга, батлах тухай мэдээлэл.
6. Санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, үр дүнг гаргах Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг энэхүү тогтоолын Хавсралт №2-ийн дагуу баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №3-ийн дагуу баталсугай.
9. Саналын хуудсаар урьдчилан санал өгөх боломжийг хангаж, саналын хуудсыг урдчилан хүлээн авах хугацааг 2026 оны 03 сарын 23-ны өдрөөс эхлэн 03 сарын 30-ний өдрийн 12:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хурлын даргаар жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд-ыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.МӨНХЦЭЦЭГ



GOLOMT BANK

BOARD OF DIRECTORS RESOLUTION

Date: February 24, 2026

№ 00/02

Ulaanbaatar

Call for annual general meeting of shareholders

Pursuant to the Article 59 Clause 59.4, Article 60 Clause 60.1 and Article 64, Clause 64.1, 64.3 of the Company Law of Mongolia, the Article 9 Clause 9.2.9 of the Bank's Charter, and the external voting adopted by the Board of Directors on 24th February, 2026, it is hereby RESOLVED to:

1. Call on the regular meeting of the shareholders of Golomt Bank on Monday 06th April, 2026 at 09 am at the Ballroom of the Shangri-La Hotel, Ulaanbaatar.
2. Approve the items of business as follows:
 - 2.1 Golomt Bank 2025 operational and financial report
 - 2.2 Board conclusion of the Bank's 2025 operational and financial report
 - 2.3 2025 audited financial results by independent auditor
 - 2.4 Dividend distribution decision of the Board from net profit of 2025
 - 2.5 Work report of the Board of Directors of 2025 and 2026 remuneration budget
 - 2.6 Approve the revised Golomt Bank Charter.
3. Determine the date of establishing list of shareholders who have right to attend the meeting as of 16th March, 2026.
4. Date for announcing about calling on the shareholders' meeting, shall be pursuant to the Clause 65.4 of Article 65 of the Company Law of Mongolia.
5. Approve the list of materials that are available for the shareholders to review as follows:
 - 5.1 Golomt Bank 2025 operational and financial report;
 - 5.2 Board conclusion of the Bank's 2025 operational and financial report;
 - 5.3 Information on 2025 audited financial results by independent auditor;
 - 5.4 Dividend distribution Resolution of the Board from net profit of 2025;
 - 5.5 Work report of the Board of Directors of 2025 and 2026 remuneration budget
 - 5.6 Information on revised of Golomt Bank Charter.
6. Approve the members of the Tabulation Committee in charge of counting the votes and the calculation of the results, as indicated in the Appendix №1 of this resolution.
7. Approve the Shareholders' meeting organization committee members as indicated in the Appendix №2 of this resolution.
8. Approve the voting format by the Appendix №3 of this resolution.
9. Grant access to external voting system to all Shareholders from 23rd March, 2026 and deadline for the submission of external voting prior to meeting shall be set as 12 noon on 30th March, 2026.
10. The Chairperson of the Shareholders' meeting shall be the representative of minority shareholder, Golomt Bank President Mr. G.Ganbold.

CHAIRPERSON

CH.MUNKHTSETSEG

